



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АУДИТ ХИЙСЭН
ҮНДЭСЛЭЛ**

Үндэсний аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН НЭР: “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”

АУДИТЫН КОД: УАГ-БНАТАГ-/2018/04-ГА



Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрт нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүний эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал эрсдэлтэй түвшинд байна.

Баянхонгор хот

2018.06.26

АГУУЛГА

	Товчилсон Үгийн тайлбар.....	1
	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН.....	2
	“ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д.....	4
	ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН	4
	1.1. Сургуулиуд төсвийн төсөл боловсруулахдаа Үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоог Боловсрол соёл урлагийн газрын Санхүү төрийн сангийн хэлтэст гаргаж буй хүүхдийн тооноос зөрүүтэй төлөвлөсөн байна.	4
	“Үдийн цай” хөтөлбөрт нийлүүлж байгаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний шинжилгээ хийлгэж буй үйл явц тодорхой бус байгаагаас хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл хангагдаагүй байна.	7
	2.1. Захиалагч тендерт шалгарсан нэгж өртгийг тооцож, баримталж ажиллаагүйгээс гүйцэтгэгчид илүү санхүүжилт олгож байна.	7
Тайланг бэлтгэсэн:	2.2. Үдийн цай хөтөлбөрийн ирцийн үр дүнд бий болсон хэмнэлтийг аймгийн ИТХ-ын тодотголоор зардал хооронд тодотгон батлуулсан байна.	8
Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	2.3. Аймгийн төвийн сургуулиудад үдийн цай хөтөлбөрийн бүтээгдэхүүн нийлүүлж буй зарим гүйцэтгэгч гэрээний үнийг баримтлаагүй байна.	9
	2.4. “Үдийн цай” хөтөлбөрт нийлүүлж байгаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд хийлгэж буй итгэмжлэгдсэн шинжилгээний дүгнэлт нь зохих шаардлагад нийцэхгүй байна.	11
	Үдийн цай хөтөлбөрт тавих өдөр тутмын хяналтыг сургуулиуд хэрэгжүүлж байгаа боловч бүтээгдэхүүний орц нормд тавих хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.....	12
<i>Уг тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын</i>	3.2 Үдийн цай хөтөлбөрт журамд заасны дагуу аймгийн ЭМГ, МХГ-аас хяналт хийсэн байна.	13
<i>Цахим хуудаснаас үзнэ үү:</i>	АУДИТЫН ДҮГНЭЛТ Error! Bookmark not defined.	
<u>www.audit.bayankhongor.mn</u>	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ Error! Bookmark not defined.	
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584, 70442424 дугаарын утсаар харилцана уу.</i>		

Хаяг: Баянхонгор сум, Номгон 1-р баг, Төр захиргааны ордон 3-р давхар

Товчилсон Үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 тоот тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ:

Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. / Асуудлын шинжилгээ хавсралт №2-д үзүүлэв/
Үүнд:

- Үдийн цай хөтөлбөрийн төлөвлөлт, худалдан авах ажиллагааг оновчтой зохион байгуулсан эсэх
- Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, дү дүн
- Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд тавьж байгаа хяналтыг үр дүнтэй үр дүнтэй зохион байгуулсан уу

Аудитыг Баянхонгор аймгийн төвийн Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Баян-Ойт, Соого Сейко зэрэг 6 сургуулийг хамруулан 2016-2017 оны санхүүгийн тайлан тэнцэл, төлөвлөгөө, мэдээ, судалгаа, үдийн цай хөтөлбөрийн холбогдох бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримтад хавсаргав.

Ингэхдээ холбогдох хууль, эрхийн актыг судлах, татварыг хөнгөлж, чөлөөлсөн мэдээ, судалгаанд дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга, лавлагаа авах зэрэг аргуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

**“ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН****Ерөнхий мэдээлэл**

“Тэтгэмж мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2006 оны 47 дугаар тогтоол, “Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУ-ны сайд, ЭМС-ийн 2006 оны 379/341 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулиудад “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам” батлагдаж, хөтөлбөрийг 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн байна.

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор нэг хүүхдэд олгох үдийн цайны зардлыг өдөрт 600 төгрөгөөр тогтоожээ.

2016 онд “Үдийн цай” хөтөлбөрт аймгийн төвийн ерөнхий боловсролын 6 сургуулийн 1-5 дугаар ангийн 3905 хүүхдийг, 2017 онд 4096 сурагчдыг хамруулахаар тооцон 2016 онд 368.4 сая, 2017 онд 374,3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 2016 онд 375,3 сая төгрөг, 2017 онд 373,6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

**БҮЛЭГ
1**

Үдийн цай хөтөлбөрийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн үү?

Санхүү төрийн сангийн хэлтсийн боловсруулсан төсвийн төслийн 2016 оны хүүхдийн тоо нь бодит байдлаас зөрүүтэй байсан бол 2017 оноос хүүхдийн бодит тоо, статистик прогнозыг зөв тусгаж төсвийн төслийг боловсруулсан байна

1.1. Сургуулиуд төсвийн төсөл боловсруулахдаа Үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоог Боловсрол соёл урлагийн газрын Санхүү төрийн сангийн хэлтэст гаргаж буй хүүхдийн тооноос зөрүүтэй төлөвлөсөн байна.

Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж буй аймгийн төвийн 6-н сургууль Төсвийн тухай хуульд заасны дагуу Төсвийн төслийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст жил бүр ирүүлсэн байна. Аудитын явцад сургуулиудын ирүүлсэн 2016, 2017 оны төсвийн төсөлд тусгагдсан Үдийн цай хөтөлбөрийн зардлын төлөвлөлтөнд дүн шинжилгээ, ярилцлага хийлээ.

Сургуулиуд төсвийн төсөл боловсруулахдаа үдийн цайнд хамрагдах хүүхдийн тоог бодитой тооцоолоогүйгээс Боловсрол соёл урлагийн газрын Санхүү төрийн сангийн хэлтэст гаргаж буй хүүхдийн тооноос 2016 онд 20375 хүүхэд өдрөөр, 2017 онд 6440 хүүхэд өдрөөр тус тус зөрүүтэй байна. Тоон мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

Сургуулийн нэр	2016 он			2017 он		
	Төсвийн төслөөр	СТСХ-ийн төлөвлөж буй	зөрүү	Төсвийн төслөөр	СТСХ-ийн төлөвлөж буй	зөрүү
Номун далай цогцолбор сургууль	136050	147100	-11050	165125	158560	6565
Номгон ахлах сургууль	169745	172645	-2900	169080	171420	-2340
Эрдэнэмандал ахлах сургууль	99375	92725	6650	113935	93805	20130
Эрдэм	104445	73685	30760	112900	107665	5235
Баян-Ойт цогцолбор	74225	73685	540	67940	86685	-18745
Соого сейго сургууль	58645	62270	-3625	62130	66535	-4405
Дүн	642485	622110	20375	691110	684670	6440

Тухайлбал: Үдийн цай хөтөлбөрийн төлөвлөлтийг хэрхэн төлөвлөж байгаа талаар сургуулиудын нягтлан бодогчтой ярилцлага хийж, тодруулахад хүүхдийн тоог сургалтын менежерийн гаргаж өгсөн тоогоор төлөвлөж байгаа бөгөөд бага ангийн суралцаж байгаа хүүхдийн статистик тоонд тулгуурлан 5-р анги төгсч байгаа хүүхдийн тоо болон шинээр 1-р ангид элсэн сурагчдын тоог харгалзаж төлөвлөж байна гэсэн тайлбар өгөв.

Харин 1-р ангид элсэн суралцагчийн тоог сургуулиуд хүчин чадлаас хамааруулан харилцан адилгүй төлөвлөж байна.

Тухайлбал: Соого сейко, Баян-Ойт сургуулиуд 5-р анги төгсөх ангийн тоог харгалзан тооцож хүүхдээ төлөвлөдөг бол бусад сургуулиуд багийн 5 настай хүүхдийг тоог харгалзан хүүхдийн тоог төлөвлөсөн байна.

Тухайн төсвийн төсөлд ирүүлсэн хүүхдийн тоог аймгийн боловсролын газраас жил тутам гаргаж буй гарын авлагын /сургуулиудын статистик үзүүлэлт/ хүүхдийн тоотой уялдуулан үзэхэд 2016 онд 20375, 2017 онд 6440 хүүхэд өдрөөр зөрүүтэй тооцсон байна. Цаашид аймгийн БСУ-ын газар, Аймгийн СТСХ-тэй хамтарч, хүүхдийн тоог зөв тооцоолж, төлөвлөж байх зөвлөмжийг ЕБС-ын удирдлагуудад хүргүүлэв.

1.2. Санхүү төрийн сангийн хэлтсийн боловсруулсан төсвийн төслийн 2016 оны хүүхдийн тоо нь бодит байдлаас зөрүүтэй байсан бол 2017 оноос

хүүхдийн бодит тоо, статистик прогнозыг зөв тусгаж төсвийн төслийг боловсруулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс аймгийн боловсрол, соёл урлагийн газраас ирүүлсэн хүүхдийн тоонд үндэслэн үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг төлөвлөсөн байна. Батлагдсан үдийн цайны төлөвлөгөөг аудитад хамрагдсан 2016, 2017 оноор төсвийн мэргэжилтнээс авч статистик мэдээ, хүүхдийн тооны прогнозоор тооцож үзэхэд 2016 онд 655460 хүүхэд өдөр буюу 393.3 сая төгрөг батлагдахаар тооцоо гарсан боловч тухайн онд 338.2 сая төгрөгөөр батлагдсан байгаа нь хүүхдийн тоонд үндэслэн төлөвлөөгүй байна.

Аймгийн СТСХ-ийн 2016 оны төлөвлөлт

Хүснэгт № 2

/сая.төг/

№	Сургуулийн нэр	Нийт хүүхэд өдөр	Норм	Жилд батлагдвал зохих	2016 Батлагдсан	Зөрүү	2016 ИТХ Тод-1	2016 ИТХ Тод
1	Номун далай	147,100	600	88,3	60,4	27,8	85,6	84,3
2	Номгон	172,645	600	103,6	92,2	11,3	93,2	93,2
3	Эрдэнэмандал	92,725	600	55,6	53,3	2,3	49,4	49,4
4	Эрдэм	107,035	600	64,2	60,4	3,8	57,4	62,7
5	Баян-Ойт	73,685	600	44,2	36,6	7,6	44,1	44,1
6	Соого сейго	62,270	600	37,4	35,2	2,2	32,8	34,7
	Дүн	655,460		393,3	338,2	55,1	362,4	368,4

Тухайлбал: Номундалай ахлах сургуулийн хүүхдийн тоог тооцооллын алдаа гаргаж зөрүүтэй төлөвлөсөнтэй холбоотой тайланд онд бэлтгэн нийлүүлэгчид төлөх өр хуримтлагдаж эхэлсэн тул төсөвт тодотгол хийж асуудлыг шийдвэрлэжээ.

Харин 2017 оны төвийн төслийг боловсрол соёл урлагийн газраас ирлүүлсэн тоотой уялдуулан төлөвлөсөн байна.

Аймгийн СТСХ-ийн 2017 оны төлөвлөлт

Хүснэгт № 3

/сая.төг/

№	Сургуулийн нэр	Нийт төлөвлөсөн хүүхэд өдөр	Норм	Жилд батлагдвал зохих	2017 Батлагдсан	Зөрүү	2017 Тод-1	2017 Тод-2	АЗД-ын Захирамж
1	Номун далай	158,560	600	95,136	95,136.0	0.0	83,169.5	83,169.5	81,518.8
2	Номгон	171,420	600	102,852	102,852.0	0.0	99,652.0	96,152.0	95,700.4
3	Эрдэнэмандал	93,805	600	56,283	56,283.0	0.0	49,895.5	49,895.4	49,895.4
4	Эрдэм	107,665	600	64,599	64,599.0	0.0	60,218.6	56,939.2	58,199.2
5	Баян-Ойт	86,685	600	52,011	52,011.0	0.0	50,211.0	50,211.0	51,853.2
6	Соого сейго	66,535	600	39,921	39,921.0	0.0	39,581.0	39,581.0	37,181.0
	Дүн	684,670		410,802	410,802.0	0.0	382,727.6	375,948.1	374,348.0

**БҮЛЭГ
2**

Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн ямар байна вэ?

“Үдийн цай” хөтөлбөрт нийлүүлж байгаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний шинжилгээ хийлгэж буй үйл явц тодорхой бус байгаагаас хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл хангагдаагүй байна.

2.1. Захиалагч тендерт шалгарсан нэгж өртгийг тооцож, баримталж ажиллаагүйгээс гүйцэтгэгчид илүү санхүүжилт олгож байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 2016, 2017 оны үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх компанийн тендер шалгаруулалтыг явуулахдаа хамгийн бага үнийн саналд үндэслэн шалгаруулсан байна.

Тендерт шалгарч гэрээ байгуулсан компаниудад үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг олгохдоо сургуулиудын тухайн сарын хүүхдийн тооны бодит гүйцэтгэлээр тооцож олгосон хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг үндэслэн сар тутамд санхүүжилтийг шилжүүлсэн байна.

Сургуулиуд нь нэг хүүхэд өдөрт 600 төгрөгөөр тооцож үдийн цайны менюг 7 хоногоор зохиож батлуулан мөрдөж ажиллажээ. Өөрөөр хэлбэл нэг хүүхэд өдөрт 600 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн олгож, тухай сарын гүйцэтгэлийг үндэслэн нийлүүлэгч компанид санхүүжилтийг олгож байжээ.

Эндээс харахад хамгийн бага үнийн санал буюу 600 төгрөгөөс доогуур үнээр хүнсний бүтээгдэхүүн нийлүүлнэ гэж тендерт шалгарч гэрээ байгуулсан атлаа 600 төгрөгөөр тооцож санхүүжилтээ авч байгаа нь тендер шалгаруулалт ач холбогдолгүй, үр өгөөжгүй, нэр төдий зүйл болохыг харуулж байна.

Тухайлбал: Тосуйн гол ХХК Соого Сейкео сургуульд үдийн цай нийлүүлэх тендерт шалгарч, 1 хүүхэд өдөрт дунджаар 556,12 төгрөгийн хоол нийлүүлж, 21752,5 мянган /395хүүхэд*98хоног*556,12төг/ төгрөгийн/зөвхөн хоолны/ санхүүжилт авах гэрээ байгуулжээ. Тухайн жилийн гүйцэтгэлээр дунджаар 373 хүүхдийн ирцтэй 92 өдөр хооллож, 19578,7 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ. Гүйцэтгэлээр 1 хүүхэд өдөрт 570,33 /373,14 хүүхэд*92хоног=34329хүүхэд өдөр, 19578,7 мян.төг/34329 хүүхэд.өдөр/ төгрөг ногдож байна. Дээрх тоон үзүүлэлтээр санхүүжилтийн тооцоог хийж үзвэл тендерийн үнээр буюу 19104,2 /373,14хүүхэд өдөр*92 хоног*556,12гэрээний үнэ/ мянган төгрөгийн санхүүжилт олгох байтал, 19578,7 мянган төгрөг буюу 474,5 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгосон тооцоо гарч байна. Ийм маягаар санхүүжилтийг илүү олгож байгаа байдал бусад сургуулиудад

нэгэн адил давтагдаж байгаа бөгөөд 2017 оны дүнгээр тендерийн үнийн хэмнэлтээс 19.9 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон тооцоо гарч байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 4

/сая. төг/

Баянхонгор сумын сургуулиудын 2017 оны үдийн цай нийлүүлэхээр батлагдсан төсөв, гэрээний гүйцэтгэл							Гүйцэтгэл хүүхэд өдрөөр	Олгосон дүн	Гүйцэтгэлээр нэг хүүхэдэд олгосон дүн	Зөрүү	Илүү олгосон санхүүжилт
№	сургуулийн нэр	хүүхэд өдөр	Батлагдсан төсөв	тендерт шалгарсан төсөв	нэг хүүхэдэд ногдох зардал	зөрүү					
1	Эрдэм	107,475	64.49	61.6	573.08	26.92	96990	58,2	600.0	26.90	2.61
2	Номгон	171,435	102.86	99.6	581.21	18.79	163397	94,8	580.4	(0.80)	(0.13)
3	Эрдэнэмандал	91,080	54.65	50.8	557.49	42.51	82986	49,8	600.0	42.51	3.53
4	Номун далай	158,527	95.12	83.2	524.64	75.36	135070	81,4	602.7	78.02	10.54
5	Соого сейго	66,528	39.92	39.6	594.92	5.08	61331	36,7	598.8	3.83	0.23
6	Баян-Ойт	86,625	51.98	50.2	579.47	20.53	82203	50,8	617.7	38.24	3.14
	Дүн	681,670	409.0	385.0			621,977	371,7			19.9

Иймд цаашид худалдан авах ажиллагааны үр дүнг гармагц нэг хүүхэдэд ногдох бүтээгдэхүүний өртгийг тооцож гэрээний үнийг баримталж ажиллах зөвлөмжийг ЕБС-ын төсөв захирагч нар хүргүүлэв.

2.2. Үдийн цай хөтөлбөрийн ирцийн үр дүнд бий болсон хэмнэлтийг аймгийн ИТХ-ын тодотголоор зардал хооронд тодотгон батлуулсан байна.

Аймгийн төвийн сургуулиудад 2016 онд анх 338,3 сая төгрөг батлагдсан бөгөөд тайлант онд үдийн цайны зардлаас Эрдэнэмандал ахлах сургуульд 3.9 сая төгрөг, Соого сейкео сургуульд 0.4 сая төгрөг хэмнэгдсэнийг аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор тодотгож тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд шилжүүлэн батлуулсан байна.

2017 онд 410.8 сая төгрөг батлагдсан бөгөөд тайлант онд үдийн цайны зардлаас нийт 36.5 сая төгрөг хэмнэгдсэнийг сургуулиуд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд шилжүүлэн зохицуулалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйл “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх”, 64 дүгээр зүйлийн 64.1.2-т “тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах...” гэсэн заалтын дагуу аймгийн ИТХ-ын тодотгож, мөн хуулийн 42 дугаар зүйл “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх” 42.2-т “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж

болно” 42.2.1.г-д “түүнд шууд харьяалагдах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд” гэж заасны дагуу хийсэн байна.

Аудитад хамрагдсан нийт байгууллагын дүнгээр 2016 онд нийт 323,4 мянга, 2017 онд 685,3 мянган төгрөгийн хэмнэлт гарсныг Төрийн сангийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

2.3. Аймгийн төвийн сургуулиудад үдийн цай хөтөлбөрийн бүтээгдэхүүн нийлүүлж буй зарим гүйцэтгэгч гэрээний үнийг баримтлаагүй байна.

Сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрт бүтээгдэхүүн нийлүүлэхээр шалгарсан аж ахуйн нэгжийн 2016, 2017 онд байгуулсан гэрээний үнийг байгууллагад нийлүүлсэн үнэтэй харьцуулав.

2016 онд “Номундалай” ахлах сургуульд мах махан бүтээгдэхүүн, жимс, хүнсний ногоо нийлүүлэхээр гэрээ байгуулсан “Хөх цэнхэр нуур” ХХК нь тендерт оролцохдоо санал болгосон үнийн саналд 5 хувийн хөнгөлөлт үзүүлнэ гэж оролцсон боловч хөнгөлөлтгүй үнээр гэрээт хугацааны турш бүтээгдэхүүнээ нийлүүлсэн байна.

Гэрээнд тусгагдсанаар тооцоход мах махан бүтээгдэхүүнд 14577.0 мянган төгрөгийн 5 хувь 728.9 мянга, жимс хүнсний ногоонд нийлүүлсэн 11873.6 мянган төгрөгийн 5 хувь 593.7 мянга нийт 1322.5 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн тул гүйцэтгэгчээр эргэн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэгч компаниуд зарим бүтээгдэхүүний үнийг гэрээнд зааснаас илүү үнээр нийлүүлэх, өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг илүү нийлүүлэх, гурилан бүтээгдэхүүний бага жинтэй /грм/ бүтээгдэхүүнийг түлхүү нийлүүлэх зөрчил илэрч байна. Тухайлбал 2017 онд Соого Сейко сургуульд шингэн хүнс нийлүүлэгч Тосуйн гол ХХК 2017 оны зарим өдрүүдэд 300 төгрөгөөр нийлүүлэх чацарганы шүүсийг 400 төгрөгөөр нийлүүлсэн байна. Тус сургуульд гурилан бүтээгдэхүүн нийлүүлэгч Их тэнгэрийн хүч ХХК нь 2017 онд сүүтэй ороомгийн нэгж үнийн дээд хязгаар 300 төгрөгөөр нийлүүлэх гэрээтэй байхад 2017.11.02-нд нэг удаа 399 хүүхдэд 500 төгрөгөөр нийлүүлсэн, тухайн онд 300-400 төгрөгийн үнэтэй 60 граммаас дээш жинтэй гурилан бүтээгдэхүүн 85,41 хувийг, 200-250 төгрөгийн үнэтэй 45-50 граммын жинтэй гурилан бүтээгдэхүүн 14,59 хувийг нийлүүлэх гэрээтэй байхад гүйцэтгэлээр жин ихтэй, өртөг өндөр бүтээгдэхүүнийг дутуу, бага жинтэй, бага үнэтэй бүтээгдэхүүнийг илүү нийлүүлсэн байна. /доорхи судалгаанаас харна уу/

Их тэнгэрийн хүч ХХК-иас Соого Сейкео сургуульд нийлүүлсэн гурилан бүтээгдэхүүний үнийн харьцуулалтын судалгаа

Хүснэгт №5

нэгж үнийн түвшин /төгрөг/	гэрээгээр			гүйцэтгэлээр		
	авсан дүн /мян.төг/	хувь	хувь	авсан дүн /мян.төг/	хувь	хувь
500	-	0	85.41	199,5	2.39	76.37
400	4,108,0	44.64		1,918,4	23.03	
350	553,0	6.01			0.00	
300	3,199,5	34.76		4,244,1	50.95	
250	395,0	4.29	14.59	212,0	2.54	23.63
200	948,0	10.30		1,756,2	21.08	
150		0.00			0.00	
100					0.00	
	9,203,5	100.00	100.00	8,330,2	100.00	100.00

Энэ нь 1 хүүхэд өдөрт ногдох бүтээгдэхийн үнийг 46,34 төгрөг/313,77-267,43/-өөр хямдруулж, бүтээгдэхүүний орцыг бууруулсан байна.

Их тэнгэрийн хүч ХХК нь Эрдэнэмандал сургуульд 2017 онд 200-400 төгрөгийн үнэтэй гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээтэй байтал 450 төгрөгийн үнэтэй маахуур 1 удаа 536ш, 450 төгрөгийн үнэтэй үзэмтэй булочка 1 удаа 537 ширхгийг тус тус нийлүүлсэн байна. Тухай онд нийлүүлэх 300-400 төгрөгийн үнэтэй 60граммаас дээш жинтэй гурилан бүтээгдэхүүн 62,12 хувь, 150-250 төгрөгийн үнэтэй 40-55 грамм жинтэй гурилан бүтээгдэхүүн 37,88 хувийг нийлүүлэх гэрээтэй байхад гүйцэтгэлээр 300-400 төгрөгийн үнэтэй 60 граммаас дээш жинтэй гурилан бүтээгдэхүүн 77,39 хувь, 150-250 төгрөгийн үнэтэй 40-55 грамм жинтэй гурилан бүтээгдэхүүн 22,61 хувийг нийлүүлж, гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Их тэнгэрийн хүч ХХК-иас Эрдэнэмандал ахлах сургуульд нийлүүлсэн гурилан бүтээгдэхүүний үнийн харьцуулалтын судалгаа

Хүснэгт № 6

нэгж үнийн түвшин /төгрөг/	гэрээгээр			гүйцэтгэлээр		
	авсан дүн /мян.төг/	хувь	хувь	авсан дүн /мян.төг/	хувь	хувь
450	-	0	62.12	717,8	5.99	77.39
400	883,2	7.39		819,2	6.83	
350	579,6	4.85		2,374,1	19.81	
300	5,961,6	49.88		5,365,5	44.76	
250	1,380,0	11.55	37.88	729,5	6.09	22.61
200	2,980,8	24.94		589,2	4.92	
150	165,6	1.39		979,4	8.17	
100				411,6	3.43	
	11,950,8	100		11,986,2	100.00	

Дээрх судалгаанаас харахад 2017 онд 552 хүүхдийг 69 өдөр буюу 38088 хүүхэд өдөрт гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээтэй байхад гүйцэтгэлээр 93 өдөр буюу 44820 хүүхэд өдөр /өдөрт дунджаар 481,94 хүүхэд хамрагдсан/ гурилан бүтээгдэхүүн нийлүүлсэн байна. Бага жинтэй бага үнэтэй бүтээгдэхүүний

нийлүүлэлтийг бууруулснаар 1 хүүхдэд ногдох бүтээгдэхүүний үнэ болон орцыг нэмэгдүүлэх боломжтой байсан хэдий ч хүүхдийн ирцийн тооны бууралтаас /70,06=552-481,94/ хамаарч нэг хүүхэд өдөрт ногдох үнийн дүнг 43,34 төгрөг/43,34=313,77-267,43/ төгрөгөөр бууруулсан байна.

Дээрх байдлын талаар сургуулиудын удирдлагуудтай ярилцлага хийхэд “худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хамгийн бага үнийн санал ирүүлсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байгаа нь чанаргүй бүтээгдэхүүн нийлүүлэх, орц нормын хэмжээ алдагдах нөхцөлийг бүрдүүлж байна” гэсэн тайлбарыг өгч байв.

Иймд цаашид хүүхдэд өгөөжтэй, шим тэжээлийн зохистой хэмжээнд тулгуурласан техникийн тодорхойлолтыг боловсруулж, худалдан авах ажиллагааны аргыг оновчтой зохион байгуулахад арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэв.

2.4. “Үдийн цай” хөтөлбөрт нийлүүлж байгаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд хийлгэж буй итгэмжлэгдсэн шинжилгээний дүгнэлт нь зохих шаардлагад нийцэхгүй байна.

Үдийн цай хөтөлбөрт нийлүүлж байгаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, гурилан болон бэлэн бүтээгдэхүүнийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораторид эрүүл ахуйн шинжилгээ хийж байна.

Аудитаар сургуулиудын үдийн цай хөтөлбөрт нийлүүлж байгаа бүтээгдэхүүнд хийлгэсэн шинжилгээний бичгийг авч шалгаж үзэхэд бүтээгдэхүүн нийлүүлэгчид нь мах борлуулдаг аж ахуйн нэгжээс давхар худалдан авч нийлүүлдэг, тэдгээрээс авсан шинжилгээний бичиг нь хувилсан, их хэмжээний бүтээгдэхүүнд шинжилгээ хийлгэсэн байна. Энэ шинжилгээний бичиг нь тухайн бүтээгдэхүүний бичиг мөн эсэхийг нотлох бололцоогүй байна.

Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2006 оны 379/341 дүгээр тушаалаар баталсан Ерөнхий боловсролын сургуулийн “үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам”-ын 3.4-т заасан бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх” гэсэн заалтыг бүрэн хангаж чадахгүй байна.



Хүнсний бүтээгдэхүүнд хийх лабораторийн шинжилгээний талаар Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал эмнэлгийн албаны даргаас тодруулахад “шинжилгээний бичгийг үнэт цаасаар хэвлэгдсэн маягтаар тухайн бүтээгдэхүүн тус бүрт гаргадаг, хуулбарласан бол хүчингүй” гэсэн тайлбар өгсөн. /Шинжилгээний хуудсыг зургаар оруулав/

Харин гурилан бүтээгдэхүүнийг аймгийн мэргэжлийн хяналтын газарт сарын давтамжтайгаар шинжлүүлдэг бөгөөд бусад бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн он, сав баглаа боодол, гарал үүслийн бичгээр бүтээгдэхүүнийг хүлээн авч байна.

Иймд цаашид хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг хангаж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэв.

БҮЛЭГ 3	<i>Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулж байна үү?</i>
	<i>Үдийн цай хөтөлбөрт тавих өдөр тутмын хяналтыг сургуулиуд хэрэгжүүлж байгаа боловч бүтээгдэхүүний орц нормд тавих хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.</i>

3.1. Хяналтын зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ орц норм, хэмжээнд хяналт тавихгүй байна.

Хүүхдийн үдийн цайнд тавих өдөр тутмын хяналтыг сургуулийн эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл, сургуулийн эмч, бага ангийн сургалтын менежер, жижүүр багшийн бүрэлдэхүүнтэй хяналтын зөвлөл хэрэгжүүлж ажиллаж байна.

Аудитаар сургуулиудын хяналт тавьж ажиллаж байгаа байдалтай танилцахад Эрдэнэмандал ахлах сургууль болон эрдэм ахлах сургуулиуд нь хяналтын зөвлөлийн 5 гишүүнийг ажлын 5 өдөрт хуваарилан нэг нэг өдрөөр хяналт тавьж байхад Номгон ахлах сургуульд тухайн өдөр жижүүр хийж буй багш, Баян-Ойт сургуульд сургуулийн эмч хяналт тавьж ажиллаж байна.

Хяналтын зөвлөл нь хяналтын дэвтэрт тухайн өдрийн хийсэн үдийн цайны нэр төрөл, болон амт чанарын талаар бичиж тэмдэглэсэн боловч орц норм, жин хэмжээний талаар огт бичээгүй, Эрдэм ахлах сургууль, Соого сейко сургуулиудад үдийн цай хэмжих жин байхгүй байв.

Иймд цаашид үдийн цайны хяналтыг сайжруулан орц норм, жинг өдөр тутамд хэмжиж хяналтын дэвтэрт бичилт хийж, үр дүнг дүгнэн санхүүжилт олгохдоо харгалзан үзэж байх зөвлөмжийг аймгийн төвийн ЕБС-ийн төсөв захирагч нарт хүргүүлэв.

3.2 Үдийн цай хөтөлбөрт журамд заасны дагуу аймгийн ЭМГ, МХГ-аас хяналт хийсэн байна.

БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайд нарын 2006 оны 379/341 тоот тушаалаар батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журмын 6.1-д “ Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн болон боловсрол, соёлын газар, мэргэжлийн хяналтын байгууллага хамтран хяналт тавина” гэж заасан байна.

Үүний дагуу аймгийн ЭМГ-ын хяналт тавьж буй эсэхийг тодруулахад 2016 оны 12 дугаар сард үдийн цай хэрэгжүүлэгч, иргэн аж ахуйн нэгжийн хоол үйлдвэрлэх үйлчилгээний ажилчдад чадваржуулах сургалтыг зохион байгуулж, Баян-Ойт, Номундалай ахлах сургуулийн үдийн цайнд нийлүүлж буй хоолны үндсэн шимт бодис, илчлэгийн хэмжээг тодорхойлох судалгааг хийсэн байна.

Мөн 2017 оны 9 дүгээр сард дээрх судалгааг зарим сургуулиудад хийж судалгааны үр дүнд:

“Хүнсний бүтээгдэхүүн болон үндсэн шимт бодисын илчлэгийн хэрэглээ нь Монгол хүүхдийн хоол тэжээлийн зөвлөмж хэмжээтэй харьцуулахад элсэн чихрийг 10 гр, давсыг 6 гр, ургамлын тос, тосон бүтээгдэхүүнийг 25 гр-аар илүү, хүнсний ногоог 50 гр, жимс жимсгэнийг 30-гр-аар бага хэрэглэж байгаа бол уураг 20 гр, илчлэг 97 гр-аар бага, өөх тос 3.6 граммаар илүү байгаа нь халдварт бус өвчний суурь тавигдах нэгэн эрсдэлт хүчин зүйл болж байна” гэж тайландаа тусгасан байна.

Мөн ЭМГ, Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран хийсэн шалгалтаар Үдийн цайнд нийлүүлэгдэж байгаа хүнсний бүтээгдэхүүний сонголтод судалгаа хийж үзэхэд:

“Сурагчид сургуулийн үдийн цайгаар хоногт шаардлагатай илчлэгийнхээ 10-15 хувийг авах ёстой боловч 7 хувийг авч байна” гэж тайланд тусгасан байна.

Судалгааны дүгнэлтийн мөрөөр Орон нутгийн өмчийн газарт хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг сонгохдоо хүнсний бүтээгдэхүүний сонголтод анхаарах зөвлөмж, ЭМС-ын 2013 оны 207 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай хоолны дэглэмтэй хүн, нярай, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, **ерөнхий боловсролын сургуулийн бага насны сурагчдад** зориулсан хүнсний

түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлд тавигдах шаардлагыг тогтоосон журам” “Монгол хүүхдийн хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ”-г тус тус хүргүүлсэн хэдий ч зөвлөмж хэрэгжээгүй байна.

Иймд сургуулийн үдийн цайны техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа аймгийн Эрүүл мэндийн газраас бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, сонголтод арга зүйн зөвлөгөө авч ажиллахыг сургуулиудын төсөв захирагч нарт зөвлөв.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2016 онд Мэргэжлийн хяналтын газрын даргын 2016 оны 01/08 тоот албан даалгаврын дагуу Баянхонгор сумын төвд үйл ажиллагаа явуулж буй ЕБС-иудын Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт хийсэн байна. Тухайн хяналтаар:

“Бүтээгдэхүүний дээжийг зохих журмын дагуу авч, тэмдэглэл үйлдэж буй эсэх 84 хувь, Бүтээгдэхүүний гарал үүслийн шинжилгээний бичиг 87 хувьтай гэж дүгнэсэн бөгөөд дээжийн хөргөгчний хэмийг хянаж бүртгэл хөтөлдөггүй, хүүхдийн хоол хүнсээр авбал зохих илчлэг шимт бодисын хэмжээг тооцож гаргасан боловч хянаж байх ёстой илчлэгтэй харьцуулалт хийдэггүй, Эрдэнэмандал ахлах сургууль Соого сейко сургуулиудын хоол үйлдвэрлэл явуулж буй газар нь технологийн нэг чигийн урсгал зөрчигдсэн, Соого сейко сургууль эмчгүй, Баян-Ойт сургуулийн гал тогоо гурван дамжлагын угаалга нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.” гэж тайлагнасан байна.

Мөн 2017 онд МХГ-ын даргын 01/139 тоот удирдамжаар ЕБС, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй газруудын хоол үйлдвэрлэлийн газарт хяналт хийсэн байна. Хяналтаар “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний ажлын байранд дүгнэлт гаргуулаагүй, батлагдсан хоолны цэстэй, хоолны илчлэгт шимт чанарыг технологийн картанд тусгасан боловч тухайн өдрийн хоолны цэсэнд бүрэн тусгаж тооцоогүй” гэж дүгнэсэн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2006 оны 379/341 дүгээр тушаалаар баталсан Ерөнхий боловсролын сургуулийн “үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам”-ын 6.1- д заасан хяналт тавих байгууллагууд нь үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитаар нийт 37.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36.0 сая төгрөгийн 5 зөрчилд холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Санхүү төрийн сангийн хэлтсийн боловсруулсан төсвийн төслийн 2016 оны хүүхдийн тоо нь бодит байдлаас зөрүүтэй байсан бол 2017 оноос хүүхдийн бодит тоо, статистик прогнозыг зөв тусгаж төсвийн төслийг боловсруулсан байна.
2. Тендерт шалгарсан гэрээнд заасан нэгж өртгийг тооцож, баримталж ажиллаагүйгээс гүйцэтгэгчид 19,9 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон.
3. Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд зааснаар үдийн цайны зардлын хэмнэлтийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар тодотгож зардал хооронд зохицуулалт хийж байгаа нь мөн хуулийн 42 дугаар зүйлийн холбогдох заалттай нийцэж байна.
4. Сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн гүйцэтгэгчийг ТБОНӨБАУХАТухай хуулийн дагуу “хамгийн бага” үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж байгаа нь бүтээгдэхүүний чанарт сөрөг нөлөө үзүүлж байна.
5. “Үдийн цай” хөтөлбөрт нийлүүлж байгаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд хийлгэж буй итгэмжлэгдсэн шинжилгээний дүгнэлтийг зохих шаардлагын дагуу хийлгэхгүй байгаа нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2006 оны 379/341 дүгээр тушаалаар баталсан Ерөнхий боловсролын сургуулийн “үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам”-ын 3.4 дэх заалтыг бүрэн хангаж чадахгүй байна.
6. Үдийн цай хөтөлбөрт тавих өдөр тутмын хяналтыг сургуулиуд хэрэгжүүлж байгаа боловч бүтээгдэхүүний орц норм, чанарт тавих хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Л.Баясгалангомбо танаа:

1. Хүүхэдэд өгөөжтэй, шим тэжээлийн зохистой хэмжээнд тулгуурласан техникийн тодорхойлолтыг боловсруулахад бодлого, арга зүйгээр хангаж ажиллах.

ЕБС-иудын захирал, нягтлан бодогч нарт:

1. Бүтээгдэхүүн нийлүүлэгчээс ирүүлсэн гэрээний техникийн тодорхойлолтод заасан бүтээгдэхүүний үнэ, нийлүүлэх хэмжээг баримталж, нэг хүүхдэд ногдох бүтээгдэхүүний өртгийг тооцож, түүнд хяналт тавьж ажиллах.

2. Үдийн цай хөтөлбөрт тавих өдөр тутмын хяналтыг сайжруулан орц норм, жинг өдөр тутамд хэмжиж хяналтын дэвтэрт бичилт хий, үр дүнг дүгнэн санхүүжилт олгохдоо харгалзан үзэж байх.

3. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг хангаж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллах.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2018 оны 11 дугаар сарын 01-ний дотор аймгийн Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ